



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 01

Бүрхээр

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Хөвсгөл аймаг, Мөрөн сум, АЗДТГ-ын III давхар, “Иргэний танхим”-д 2023 оны 10 дүгээр сарын 13-ны өдрийн 11 цаг 00 минутад эхэллээ.

Хуралд нийт 829622 /Найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин хоёр ширхэг хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигч оролцохоос 423107 ширхэг хувьцааг эзэмшигч, орон нутгийн төлөөлөгч 2, 19 ширхэг энгийн хувьцааг төлөөлж 1 хувьцаа эзэмшигч биеэр оролцон хурал 51 хувийн ирцтэй болов. Энэ нь Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг хангахгүй байгааг тооллогын комисс танилцуулав. /Тооллогын комиссын тогтоол, тэмдэглэлийг хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд: Хувьцаа эзэмшигч

№	Овог нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо
1	Орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Төмөрхуяг		211554
2	Орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Улам-Өсөх		211553
3	Хувьцаа эзэмшигч Э.Эрдэнэхуяг	PY87092434	19
Хуралд оролцсон нийт дүн			423126

Тооллогын комиссын дарга: Б.Одончимэг

Тооллогын комиссын гишүүн : Б.Угтах-Эрдэнэ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга: Т.Урангэрэл нар оролцов.

Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг бие даан зарласан тухай Хөвсгөл аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/69 дугаар захирамж, хуралд хүрэлцэн ирсэн орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, хувьцаа эзэмшигчийг танилцууллаа.

Сонссон нь:

Б.Одончимэг (Тооллогын комиссын дарга): Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хойшлогдсон хуралд нийт 829622 ширхэг хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигчид оролцохоос 423107 ширхэг энгийн хувьцааг төлөөлж орон нутгийн өмчийн төлөөлөгч 2, 19 ширхэг хувьцааг төлөөлж 1 хувьцаа эзэмшигч оролцож хурал 51 хувийн ирцтэй болж байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.2, компанийн дүрмийн холбогдох заалтыг хангахгүй байна.

Б.Должинсорогдог (Хурлын дарга): Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хуралдуулахаар товлон зарласан.

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2-т Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 буюу түүнээс дээш хараат бус гишүүн, саналын эрх бүхийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал шаардлага гаргасан үед ээлжит бус хурал хуралдуулахаар зааж өгсөн. Үүний дагуу Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Г.Мөнгөнхуяг 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/233 тоотой “Могойн гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Должинсорогдог миний биед хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах санал, шаардлагаа хуульд заасан баримтын хамт хүргүүлсэн.

ИТХ-ын санал шаардлагад “Могойн гол компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс хараат бус гишүүний сонгон шалгаруулалт зарлахдаа хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, тус компанийн дүрэмд заасан шалгуураас хэт өндрөөр тавьж, нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хамааралтай нэр дэвшигчдэд болон өөрсдөдөө давуу байдал үүсгэж бусад нэр дэвшигчдийн оролцох эрхийг хязгаарласан. Нэр дэвшигчдийн материалыг компанийн цахим хаяг болон гүйцэтгэх захирлын утсаар хүлээн авч байгаа нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна гэсэн зарчмыг алдагдуулсан байна.

Иймд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлаж, хууль дүрэмд заасан шаардлага хангасан нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн, томилуулах, Компанийн тухай хуулийн 61.1.2 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлахыг шаардаж байна” гэсэн байна.

Санал, шаардлага хүргүүлсний дараа төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуулийн 61.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг ажлын 10 өдөрт багтаан гаргах ёстой.

Төлөөлөн удирдах зөвлөлд уг асуудлыг танилцуулж, компаниас ирүүлсэн бусад асуудал болон санал шаардлагын дагуу шийдвэр гаргах эсэхийг хэлэлцэхээр төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 3 удаа зарласан ч нэр бүхий гишүүд ирээгүйн улмаас ирц бүрдэж хуралдаагүй.

Улмаар аймгийн ИТХ-ын даргаас 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 01/252 тоот албан бичгээр санал шаардлагын хариуг өгөхийг шаардсан учир төлөөлөн

удирдах зөвлөлийн хурлаар асуудлыг хэлэлцүүлэхээр зарласан ч ирц бүрдээгүй тул санал шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах боломж бүрдээгүй гэдэг хариуг хүргүүлсэн.

Ингээд аймгийн ИТХ-ын дарга Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7-д "Энэ хуулийн 61.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргасан байна.

Энэхүү шийдвэрээр зарласан хуралд Компанийн тухай хууль, тус компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх хүрэлцэн ирээгүй учир хурал хуралдах боломжгүй болж байна. Хурлын процедурыг холбогдох байгууллагад уламжлая.

Н.Төмөрхуяг: Төлөөлөн удирдах зөвлөлд ажилладаг нэр бүхий хувьцаа эзэмшигчид давуу байдлаа ашиглан хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрсдийн хамаарал бүхий хүмүүсийг нэр дэвшүүлж, хараат бус гишүүнээр томилдог. Эргээд Төлөөлөн удирдах зөвлөл хуралдах гэхээр хувьцаа эзэмшигч гишүүд болон хараат бус гишүүд хуралд ирдэггүй байдалтай олон сар боллоо. Өнгөрсөн хугацаанд ТУЗ-ийн хурлыг 3 удаа зарлахад ирц бүрдэж хуралдаагүй. Өнөөдөр мөн 4 дэх удаагаа ТУЗ-ийн хурал зарласан ч ирэх боломжгүй гэдгээ илэрхийлсэн байна. Энэ асуудлыг шийдвэрлэж, ТУЗ-ийн хурлын хэвийн үйл ажиллагааг хангах шаардлагатай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдээгүй тул Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид холбогдох материалыг хүргүүлэхийг даалгав.

ТАНИЛЦСАН:

ДАРГА  Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Т.УРАНГЭРЭЛ

**“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2023.10.13

№1

Мөрөн

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай


Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 заалт, 69 дүгээр зүйлийн 69.4 дэх заалт, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт, Тооллогын комиссын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд компанийн 423107 ширхэг энгийн хувьцааг төлөөлж, орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Төмөрхуяг, Э.Улам-Өсөх, 19 ширхэг энгийн хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигч Э.Эрдэнэхуяг биеэр ирж, энэ нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 51 хувийн ирцийг бүрдүүлж байгааг хурлын дарга, хурал зохион байгуулах комисст танилцуулсугай.

2. Нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх нь хуралд хүрэлцэн ирээгүй тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулах саналыг хүргүүлсүгэй.

3. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т заасны дагуу дахин товлож, нийтэд мэдээлэхийг уламжилсугай.

КОМИССЫН ДАРГА



Б.ОДОНЧИМЭГ

**“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр
сум

Дугаар 01


Мөрөн


“Могойн гол” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Нутгийн удирдлагын ордон “Иргэний танхим”-д 2023 оны 10 дүгээр сарын 13-ны өдрийн 11 цагт хийхээр зарласан.

Энэхүү хуралд нийт 829622 (Найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин хоёр) ширхэг энгийн хувьцаа эзэмшигч оролцохоос 423107 ширхэг энгийн хувьцааг төлөөлж, орон нутгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Төмөрхуяг, Э.Улам-Өсөх, 19 ширхэг энгийн хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигч Э.Эрдэнэхуяг биеэр хүрэлцэн ирсэн бөгөөд хурлын ирц 51 хувьтай байна.

Энэхүү хурлын ирц нь Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтад “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг хангахгүй байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц бүрдээгүй тул Компанийн тухай хуулийн дагуу хойшлуулах тухай саналыг хурал зарлагч аймгийн ИТХ-д хүргүүлэх, энэ тухай тооллогын комиссын тогтоол гаргахаар тогтов.


КОМИССЫН ДАРГА:  Б.ОДОНЧИМЭГ
ГИШҮҮД:  Б.УГТАХ-ЭРДЭНЭ




Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Компанийн 423107 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Хувьцаа эзэмшигч:

 Н.ТӨМӨРХУЯГ

Э.УЛАМ-ӨСӨХ

 Э.ЭРДЭНЭХУЯГ